# ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БАЯРТОГТОХ ОВОГТОЙ ТӨМӨР-ОЧИРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

| Д/Д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /хүрээгүй бол тайлбар/ | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Гаалийн байгууллагын шударга байдлыг дээшлүүлэх | | | | | | | |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 1 | Дотоод аудитын зорилгоор эрсдэлийн судалгаа шинжилгээ хийх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 90% | 100% | 2025 оны эхний хагас жилд харьяа УХШИГГ, ГЕГ-ын ХХ болон ТОГ-ын үйл ажиллагаанд хийх дотоод аудитын хүрээнд удирдамжийн хамрах хүрээг тодорхойлох зорилгоор тус газруудын 2023-2024 оны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтүүд болон Сангийн сайдын батлагдсан чиг үүрэг зэргээр судалгаа хийж хамрах хүрээг тодорхойлсон, Мөн УБГГ-т хийгдэх аудитын хамрах хүрээг тодорхойлохоор тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлийн судалгаа хийж тухайн чиглэлийн нарийвчилсан ямар үйл ажиллагааг хамрах хүрээнд тусгахыг тодорхойлоход албан хаагчдыг удирдан зохион байгуулж ажилласан. | 01.01<br>06.10 | 100 |
| 2 | Эрсдэлд суурилсан дотоод аудит хийх, холбогдох зөвлөмжийг хүргүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 85.7% | 100% | 2025 оны эхний хагас жилд 4 аудит гүйцэтгэсэн. Үүнд:<br>- №2025-01 дугаартай удирдамжийн дагуу СЭГГ-т гүйцэтгэлийн аудитын 2025.01.15-2025.01.19-ний өдрүүдэд хийж гүйцэтгэж үр дүнг ГЕГ-ын ЗЗХ-аар хэлэлцүүлэн хэрэгжилт хангалтгүй 4 зөвлөмжийн дахин тус газарт албан бичиг болон ЗДАС программаар хүргүүлсэн.<br>- ГЕГ-ын даргын баталсан №2025/02 дугаартай удирдамжийн дагуу УХШИГГ-т 2025.03.12-2025.04.02-ны хооронд хугацаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр нийт 12 асуудал илэрч "Сайжруулалт шаардлагатай" гэж дүгнэн үр дүнг Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуралдааны шийдвэрээр холбогдох 12 зөвлөмжийг хүргүүлэхийн өмнө зөвлөмж өгөх ГЕГ-ын нэгжүүдтэй холбогдох хэрэгжүүлэх боломжит | 01.01<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацааг тодорхойлсны дараа зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд ХБГ болон МТГ-т шуудангийн манифесттай холбооотой зөвлөмжийг хэрэгжүүлэх боломжит хугацааг тооцон ирүүлэх талаар дотоод зурвасыг хүргүүлсэн. Дотоод зурвасын хариуг ирсний дараа зөвлөмжүүдийг дахин нэмэлт өөрчлөлт оруулан удирдлагад танилцуулан холбогдох нэгж болон УХШИГГ-т хүргүүлнэ.<br>- ГЕГ-ын даргын баталсан №2025/03 дугаартай удирдамжийн дагуу Хуулийн хэлтсийн 2024 он болон 2025 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд дотоод аудитыг 2025.04.21-2025.05.05-ны хооронд хугацаанд хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр нийт 11 асуудал илэрч "Сайжруулалт шаардлагатай" гэж дүгнэсэн. Аудитын тайланг ГЕГ-ын ЗЗХ-аар хэлэлцүүлэх хугацаа болоогүй байгаа бөгөөд холбогдох 28 зөвлөмжийн боловсруулах тайланд тусган бэлэн болгосон. Тайлан Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдсэний дараа зөвлөмжийг баталгаажуулан хүргүүлэх болно.<br>- ГЕГ-ын даргын баталсан №2025/04 дугаартай удирдамжийн дагуу Татвар орлогын газрын 2023 он, 2024 оны үйл ажиллагаанд дотоод аудитыг 2025.04.28-2025.05.14-ний хооронд хугацаанд хийж гүйцэтгэсэн. Аудитын үр дүнгээр нийт 9 асуудал илэрч "Сайжруулалт шаардлагатай" гэж дүгнэн тайлангийн төслийг бэлтгэсэн. Аудитын тайланг бүрэн дуусган Захиргааны зөвлөлийн хуралдаанд танилцуулах хугацаа болоогүй байна.<br>- СДШХ, МТГ, УБГГ, ЗҮГГ, УВГГ-т хийгдэх дотоод аудит сүүлийн хагас жилд төлөвлөгдсөн.<br>2. СЭГГ-т хийгдсэн гүйцэтгэлийн аудитын үр дүнгээр хэрэгжилт хангалтгүй 4 ажлын холбогдох зөвлөмжийг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 01-4/1435 тоот албан бичгээр болон ЗДАС программаар хугацаатай хүргүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх хугацаа болоогүй.<br>УХШИГГ-т хийгдсэн аудиттай холбоотой зөвлөмжийн хугацааг нарийвчлан тодорхойлохоор ХБГ, МТГ-т дотоод зурвас хүргүүлсэн бөгөөд хариу ирсний дараа зөвлөмжүүдийг УХШИГГ болон МТГ, ХБГ-т хүргүүлнэ. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХХ болон ТОГ-т хийгдсэн аудитын үр дүн Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэгдэж баталгаажаагүй байгаа тул зөвлөмжүүдийг хүргүүлээгүй байна. | | |
| 3 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж үр дүнг удирдлагад танилцуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 97% | 100% | - Үндэсний аудитын газраас Сангийн яамны харьяа агентлагуудад аудит хийж байгаатай холбогдуулан Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Гаалийн байгууллагын чиг үүргийн дагуу тусгагдсан “Боомтын ачаа нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх”, “Уул уурхайн бус гадаад худалдаа”, “Гадаад худалдааг хөнгөвчилж экспортод зарцуулах цаг хугацааг 72 цагт хүргэж бууруулах” гэсэн 3 ажлын биелэлтийг ХБГ, ЭУХ, СДШХ-ээс гаргуулан авч нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж 100 хувиар үнэлүүлсэн.<br>- Сангийн яамнаас 2024 онд ирүүлсэн “Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан хүргүүлэх тухай” 03/1172 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн нэгжийн чиг үүрэгт хамааралтай 4 зөвлөмжийн биелэлтийг гарган Захиргааны удирдлагын газарт 2025.01.10-ны өдрийн 01203/5 дугаартай дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- Гаалийн ерөнхий газарт Чанарын менежментийн ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 стандартуудыг нэвтрүүлэх ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуй нэгж сонгохоор үнийн санал авахаар 3 газарт хүсэлт хүргүүлсний дагуу ирүүлсэн 3 газрын үнийн санал холбогдох мэдээллийг бэлтгэн ГЕГ-ын ЗЗХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>- Үндэсний аудитын газраас Гаалийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангийн танилцуулгыг ГУБ У.Байгалцэцэгтэй хамтран боловсруулж ГЕГ-ын ЗЗХ-аар хэлэлцүүлсэн. | 01.01<br>06.10 | 100 |
| 4 | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 98% | 100% | 2025 оны эхний хагас жилд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй ажлын цаг ашиглалт 100 хувь. | 01.01<br>06.10 | 100 |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Гаалийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаа болон Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланд явцын болон эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Гаалийн ерөнхий газрын 2025 оны хагас жил, бүтэн жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг нэгтгэн Сангийн Яаманд хугацаанд нь хүргүүлэх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 88.5% | 100% | 1. Гаалийн байгууллагын цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох байгууллага, албан тушаалтныг бодит мэдээллээр хангах, дүгнэлт өгөх зорилгоор “Гаалийн байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгдсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийсэн.<br>Тус хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, мөн 2021 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 374 дүгээр тогтоолыг үндэслэн “Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний хүрээнд Гаалийн ерөнхий газар болон зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагын 2021-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Захиргааны удирдлагын газраас хянаж, биелэлтэд Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн үнэлгээ, Захиргаа дотоод ажлын систем программын төлөвлөгөө хэсгийн Стратеги төлөвлөгөө, Гаалийн ерөнхий газрын төлөвлөгөө, нэгжийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг зорилтот түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан судалдаг болно.<br>“Гаалийн байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд 91.7 хувьтай буюу *“Тодорхой үр дүнд хүрсэн”* байна. Үүнд:<br>• 15 стратеги арга зам “Үр дүнтэй"<br>• 21 стратеги арга зам “Тодорхой үр дүнд хүрсэн"<br>• 1 стратеги арга зам “Эрчимжүүлэх шаардлагатай" байна.<br>Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хамгийн багаар үнэлэгдсэн буюу 50-70 хувийн хэрэгжилттэй доорх 3 зорилтод хүрэх арга зам, үйл ажиллагаа байгаа бөгөөд энэхүү 3 үйл ажиллагааг “Гаалийн байгууллагын 2025-2028 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд тусган, үр дүн гаргаж ажиллах дүгнэлтэд хүрсэн. | 01.01<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2. Гаалийн байгууллагын 2021-2024 онд хэрэгжиж дууссан Стратеги төлөвлөгөө, Гаалийн байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, Сангийн яаманд хүргүүлэх "Гаалийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан"-д тусгасан.<br><br>3. Гаалийн байгууллагын 2024 оны доор дурдсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн. Үүнд:<br>• Улсын Их Хурлын тогтоол – 5,<br>• УИХ-ын Байнгын хорооны тогтоол – 3,<br>• Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж – 1,<br>• Засгийн газрын тогтоол – 17,<br>• Засгийн газрын хуралдааны тэмдэглэл – 11,<br>• Засгийн газрын албан даалгавар – 2, Нийт: 39 баримт бичгийн 69 зүйл, заалт.<br>Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.3 дахь заалтыг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.<br>Дээрх тогтоол шийдвэрийн нийт 65 зүйл заалтын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ биелэлтийн дундаж 87.32 хувь байгаа бөгөөд 1 заалтын хэрэгжих хугацаа болоогүй, хасуулах саналтай 1 заалт, үнэлүүлэхгүй 2 заалт байсан.<br><br>4.Засгийн газрын 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж 88 хувиар үнэлсэн.<br><br>5.2025 оны эхний хагас жилийн эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн биелэлтийн тайланг Захиргааны удирдлагын газраас холбогдох ЗББНДБ-аас авч, нэгтгэх ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа уг биелэлтийн тайланд үндэслэн холбогдох эрх зүйн актын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бэлтгэл ажлыг ханган, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 6. Сангийн яамны харьяа агентлагийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлалын дагуу 2024 оны жилийн эцсийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн 25 тайланд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, Гаалийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланд тусган 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01-4/520 албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.<br>2.Сангийн яамнаас ГБ-ын 2024 оны үйл ажиллагааг **88.5** хувиар үнэлж ирүүлсэн ХШҮ-ний тайланд дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр ажил сайжруулах чиглэлийг ГЕГ-ын ЗББНДБ-дад дотоод зурвасаар хүргүүлсэн. Мөн үнэлгээ хийж ирүүлсэн тайлангийн үр дүнг Захиргааны зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн үнэлгээ буурсан арга хэмжээтэй холбогдох материалуудыг ДХАБХ-т нэгтгэн хүргүүлсэн. Мөн үнэлгээ буурсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг сайжруулахаар 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Гаалийн ерөнхий газрын даргаар "Сангийн яамнаас Гаалийн ерөнхий газрын 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж ирүүлсэн тайлангийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г холбогдох 10 нэгжээс санал авч ирүүлсэн 16 саналыг тусгасны үндсэн дээр боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан нэгжүүдэд батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах болон тайлагнах талаар дотоод зурвас хүргүүлсэн.<br>Гаалийн ерөнхий газрын 2025 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Сангийн яаманд хүргүүлэхээр бэлтгэн тайланд биелэлт ирүүлэх холбогдох 12 нэгжид дотоод зурвас хүргүүлэхээр бэлтгэж байна. Гаалийн ерөнхий газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн тайланг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ. | | |
| 6 | ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95.7% | 100% | ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын 2025 оны эхнхий хагас жилийн үйл | 01.01<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гаалийн газар, хороодын 2025 оны эхний хагас жилийн шалгуур үзүүлэлтийн биелэлтэд ХШҮ хийж, нэгдсэн тайланг ЗЗХ-нд хэлэлцүүлэх. | | | | ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг ГЕГ-ын даргын 2022 оны А/226 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 6.3-д заасан хугацаанд хэрэгжүүлнэ. | | |
| 7 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | 1.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээнд багтах бодлогын баримт бичгүүдээс ХШҮДАГ-ын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй тул тайлагнаагүй бөгөөд нэгжийн чиг үүрэгт хамаарал бүхий арга хэмжээг тусгасан тохиолдолд хэрэгжилтийг хангаң ажиллаж, тухай бүр нь тайлагнан ажиллах болно.<br>2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;<br>Хөгжлийн зорилтот хөтөлбөр;<br>Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл;<br>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;<br>Үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөр;<br>Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлтийн тайланг Захиргааны удирдлагын газраас холбогдох ЗББНДБ-аас авч, нэгтгэх ажлыг бүрэн гүйцэтгэж дууссаны дараа уг биелэлтийн тайланд үндэслэн холбогдох эрх зүйн актын хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангаң, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 01.01<br>06.10 | 100 |
| 8 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хүрээнд ХШҮДАГ-ын зүгээс хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн акт тусгагдаагүй тул тайлагнаагүй бөгөөд нэгжийн чиг үүрэгт хамаарал бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн акт тусгасан тохиолдолд хэрэгжилтийг хангаң ажиллаж, тухай бүр нь тайлагнан ажиллах болно.<br>2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үндсэн чиг үүрэг болох үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд тус | 01.01<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газар нь 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон 2021 оны 374 дүгээр тогтоолоор уг журамд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг удирдлага болгон ажилласан.<br>Харин Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолоор шинэ журам батлагдсантай холбогдуулан дээрх хоёр тогтоол хүчингүй болж, цаашид хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг уг 43 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>Мөн Сангийн сайдын 2018 оны 143 дугаар тушаалаар батлагдсан аргачлал, ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дугаар тушаалаар шинэчлэгдсэн аргачлал, тайлагнах хугацааны зохицуулалтыг удирдлага болгон, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>3.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын үндсэн чиг үүрэг болох дотоод аудитын ажлын хүрээнд тус газар нь дараах эрх зүйн баримт бичгийг удирдлага болгон, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Үүнд:<br>• Дотоод аудиторуудын олон улсын Мэргэжлийн практикийн хүрээ, стандарт;<br>• Засгийн газрын 2015 оны “Дотоод аудитын дүрэм батлах тухай” 483 дугаар тогтоол;<br>• Сангийн сайдын 2019 оны “Аргачлал батлах тухай” 268 дугаар тушаал;<br>• Сангийн сайдын 2019 оны “Журам, аргачлал батлах тухай” 274 дүгээр тушаал;<br>• ГЕГ-ын даргын 2025 оны А/48 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх журам”.<br>Дээрх эрх зүйн баримт бичгүүдэд нийцүүлэн дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг таньж тогтоон санд бүртгэхэд хамтран ажиллах, бууруулах санал гаргах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Тус зорилтын хүрээнд ХШҮДАГ нь ГЕГ-ын даргын 2022 оны А/342 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу нэгжийн түвшинд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, бүртгэх ажлыг зохион байгуулсан. Үүнд:<br>• Нэгжийн дарга, ГУАБ, ГУБ нараас асуулга авч, 3 эрсдэлийг илрүүлж, хүчин зүйлийг тодорхойлсон;<br>• Эрсдэл тус бүрийг давтамж, нөлөөлөл, үр дагавраар үнэлж, дунд зэрэгтэй, өндөр, бага эрсдэлийн түвшин тогтоох үйл ажиллагаанд оролцсон;<br>Нэгжийн түвшинд бууруулах боломжтой гэж үзсэн дунд болон бага эрсдэлд мониторинг, зөвлөмж, хамтын ажиллагааны хүрээнд шийдвэрлэх арга хэмжээг авч ажилласан. | 01.01<br>06.10 | 100 |
| 10 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт:<br>ГЕГ-ын даргын А/190 дүгээр тушаалаар батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалд ёс зүйтэй холбоотой шалгуур үзүүлэлтийн нэмэлт өөрчлөлт оруулах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 100% | - Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлалын төсөлд ёс зүйн холбогдох 6 шалгуур үзүүлэлтийг боловсруулсан.<br>ГЕГ-ын д<br>аргын А/190 дугаар тушаалаар батлагдсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлалд ёс зүйтэй холбоотой шалгуур үзүүлэлтийн нэмэлт өөрчлөлт оруулах үйл ажиллагаа нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоол батлагдсантай холбоотойгоор түр хугацаанд хойшлогдсон.<br>Иймд 2025 оны сүүлийн хагас жилд тус аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн болно. | 01.01<br>06.10 | 100 |
| 11 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт:<br>Төлөвлөлт, тайлагналт, үр дүнг сайжруулах зорилгоор албан хаагчдын чадавхжуулах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 100% | - 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр ХШҮДАГ-аас “Гаалийн байгууллагын үйл ажиллагааны тайлагнал, анхаарах асуудал” сэдэвт сургалтаар Засгийн газрын 2020 оны 206 дугаар болон 2021 оны 374 дүгээр тогтоолууд хүчингүй болж, Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой мөн ГЕГ-ын ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн тайлагналт, Гаалийн байгууллагын үйл | 01.01<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зорилгоор сургалт зохион байгуулах. | | | | ажиллагааг Сангийн яаманд тайлагнахтай холбоотой анхаарах асуудлуудын хүрээнд нийт 162 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулан сургалт зохион байгуулсан.<br>- | | |
| 12 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт: Гаалийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах, үр дүнг танилцуулах сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 100% | - Гаалийн байгууллагын 2024 оны хэрэглэгчийн үнэлгээний судалгааны үр дүнгийн тайланг, 2025 онд үнэлгээг өсгөхөд чиглэсэн өөрийн нэгжийн онцлогт тохирсон арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хагас бүтэн жилээр тайлагнан ажиллах талаар чиглэлийн хамт ГЕГ-ын ЗББНДБ-дад 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн дотоод зурвасаар, харьяа ГГХ-дод 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 01-4/666 тоот албан бичгээр хүргүүлсэн. Чиглэлийн хүрээнд зохион байгуулсан ажлын үр дүнг 2025 оны эхний хагас жилийн ЗББНДБ болон ГГХ-ын үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад үнэлнэ. Гаалийн байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа”-г 2025 оны 4 дүгээр улиралд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. | 01.01<br>06.10 | 100 |
| 13 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт: ЗББНДБ-аас ирүүлсэн цаг үеийн шинжтэй батлагдсан төлөвлөгөөнүүдийн биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 100% | ХБГ-аас ирүүлсэн дотоод зурвасын дагуу дараах төлөвлөгөөний биелэлтүүдэд ХШҮ хийж хугацаанд нь хариуг хүргүүлсэн. Үүнд:<br>- “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 26 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах арга хэмжээний 2025 оны нэгдүгээр улирлын биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж хэрэгжилтийг 80 хувиар үнэлэн тус газарт дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Гаалийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 8 ажлын 2025 оны 2 дугаар улирлын биелэлтэд ХШҮ хийж 84.4 хувиар үнэлж тус газарт дотоод зурвасаар хүргүүлсэн. | 01.01<br>06.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - АТГ-ын мөрдөн шалгах хэлтсээс ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд Гаалийн хяналт, шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх ажлын төлөвлөгөөний 2025 оны 1 дүгээр улирлын 6 ажлын биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж 80 хувиар үнэлэн тус газарт дотоод зурвасаар хүргүүлсэн. | | |
| 14 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт: ГЕГ-ын даргын 2016 оны А/64 тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын зөрчлийг хянан шалгах журам"-ын шинэчилсэн төслийг боловсруулж ажлын хэсэгт танилцуулах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 100% | - ГЕГ-ын даргын 2016 оны А/64 тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын зөрчлийг хянан шалгах журам" нь одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч эрх зүйн шинэчлэлтэй уялдан зарим зохицуулалт нь шинэ хууль, дүрэм, журамтай нийцэхгүй, уялдаа холбоо сул байгаагаас практикт хүндрэл учруулах нөхцөл бүрдсэн.<br>Иймд журмыг шинэчлэх ажлын хүрээнд:<br>-Төрийн албаны тухай хууль (2017),<br>-"Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам" (2019 оны 36/32 тоот тушаал),<br>-Захиргааны ерөнхий хууль,<br>-ЗГ-ын 2009 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн сахилгын дүрэм" зэрэг эрх зүйн баримт бичигт тулгуурлан судалгааг хийж, мөн сахилгын болон ёс зүйн зөрчлийн зааг ялгааг тодорхойлох чиглэлээр судлаачдын бүтээл, тайланг ашигласан.<br>- Үүний үр дүнд "Гаалийн улсын байцаагчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх журам"-ын шинэчилсэн төслийг боловсруулж, холбогдох ажлын хэсэгт танилцуулсан | 01.01<br>06.10 | 100 |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ТӨМӨР-ОЧИР /.................................../ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

## ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТӨМӨР-ОЧИРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор | - | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна. | - Удирдлагын академиас зохион байгуулсан “Төлөвлөлт хяналт шинжилгээ, үнэлгээ богино хугацааны сургалтад хамрагдаж сертификат авсан”.<br>- Хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан сургалт-хэлэлцүүлэгт оролцсон. | 02.24-02.25 | 100 |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Бие дааж уншиж судалсан байна. | - Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 7 сарын дугаарт "Олон улсын гэрээний хэрэгжилтийн асуудал, Гаалийн горимыг уялдуулах, хялбарчлах олон улсын конвенцийн жишээгээр" эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж илгээсэн, хянагдаж байгаа.<br>- Сангийн яам Баянгол дүүргийн Дотоод аудитын алба хамтран зохион байгуулсан Дотоод аудитын үзүүлэх сургалтад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хамрагдсан.<br>- Чанарын менежментийн ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, судалгаа хийх ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газарт дээрх стандартуудын нэвтрүүлэх судалгааг хийж холбогдох зөвлөх үйлчилгээг үзүүлэх газартай гэрээ байгуулан хэрэгжүүлж эхэлсэн. | 01.01-06.10 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ .................... /Б.ТӨМӨР-ОЧИР/ 2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ТӨМӨР-ОЧИРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт оноо (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | | 63,6 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | МУИС-ийн Эрх зүйн сэтгүүлд нийтлэл хэвлүүлэх | | 15 |
| 2. | Чанарын менежментийн ISO 9001:2015, Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001:2022 стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, судалгаа хийх | | 15 |
| **Мэдлэг. ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:** | | | 15 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 13 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 13 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 13 |
| 4. | Манлайлах | 13 |
| 5. | Багаар ажиллах | 13 |
| 6. | Харилцаа | 13 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 13 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт | 63,6 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ | 13 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт | — |
| **Нийт оноо=** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 91,6 |

**Үнэлгээ өгсөн:**

Гаалийн ерөнхий газрын дарга

**Төсвийн шууд захирагч:**

.................... (Р.Отгонжаргал)

2025.06.25............ (огноо)

**Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:**

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

**Нэгжийн дарга:**

.................... (Б.Төмөр-Очир)

2025.06.10............ (огноо)